



Хотын ногоон байгууламж

Томоохон төв суурин газрын ойролцоо ногоон байгууламж буй болгох технологи

Тус технологийг Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 1-р баг Зүүнсайханд нэвтрүүлсэн бөгөөд далайн түвшнээс дээш 1444 м-т, Х.Ө43034/46.4//, З.У104026/39.6//-т оршдог. Хот орчмын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор анх удаа говийн нөхцөлд 48м-ийн гүнтэй 4 худаг гаргаж услалтын систем байгуулан, 80 га газарт хайлас, сухай, буйлс, шар хуайс зэрэг говийн ховордсон модлог ургамлыг дараах үе шаттайгаар тарималжуулжээ.

- 62000 м шуудууг /шан/ МТЗ-510 трактор, ПЛН-3-35 анжис ашиглан 35-40 см гүнд татаж хөрсийг сийрүүлэн, трактороор татсан шуудууг тэгшилж булсаны дараа сул хөрсөнд тогоолж хайрцаг хэлбэрээр мод суулгах нүх гаргаж засна.
- Цэнэг усалгаа хийсэний дараа МТЗ-510 тракторт агрегаталсан модны нүх ухагч төхөөрөмж ашиглан 50x50 см хэмжээтэй нүхийг ухаж бэлтгэнэ.
- Ухаж бэлтгэсэн нүх бүрийг 5 кг бууцаар бордож, хөрстэй хольж хутган холимог хөрс бэлтгэх бөгөөд энэ ажилд татаж нөөцөлсөн 200 тн орчим бууцыг зарцуулсан.
- Ойжуулсан 80 га талбайг услах худагт ус татах насос суурилуулж, ус нөөцлөх сав (ёмкост) байрлуулж ашиглалтад оруулахын зэрэгцээ 1000 м урт, 6 эгнээ бүхий ойн зурваст таригдсан мод бүрийг жигд услах үүднээс 12100 м хуванцар хоолойг холбож услалтын систем тавина.
- Ойн зурвасанд сухайг мөчрийн тайрдсаар, буйлсыг үрээр шууд тарималжуулав.
- Ойжуулах ажлын үр дүнд хайлас 21000 ширхэгийг суулгацаар тарьсаны 18500 ш буюу 88,0% амьдралттай ургасан.
- Тарьсан модны жилийн өсөлт нь 10-30 см байлаа.

1-р зургийн тайлбар: Ойн зурвасын усалгааны худгийн ерөнхий төрх байдал
2-р зургийн тайлбар: Өмнөговь аймгийн элсний нүүдэл, салхины хамгаалалтын ойн зурвасын ерөнхий төрх байдал.



Байршил: Өмнөговь аймаг

Технологийн хамрах хүрээ: 80 га газар

Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл: Ургамлын

Газар ашиглалтын төрөл: бэлчээр байсан бол технологи нэвтрүүлсний дараа ойн зурвас болсон

Уур амьсгал: Хуурай, сэрүүн

MONCAT мэдээллийн сангийн нэрзүй: QT MON-3

Холбогдох арга барил: Бүртгэгдээгүй

Технологийг нэвтрүүлсэн: Ч.Одсүрэн

Технологийн талаарх мэдээллийг өгсөн: Ч.Одсүрэн





Технологийг бүртгэсэн: А.Хауленбек, Л.Мөнхнасан, Ц.Ганчөдөр

Он, сар, өдөр: 2008.09.07

Эмхэтгэгчдийн тайлбар: Энэхүү технологи нь төв суурин газрын ойролцоо агро-ойжуулалт хийх үндсийг тавьснаараа онцлог юм. Ийнхүү 4 эгнээ бүхий ойн зурвасын хоорондох талбайд жимс, жимсгэний сөөг суулгах, болон хүнсний ногоо тариалах зориулалтаар ашиглах боломжтой юм. Томоохон суурин газруудын төв орчмын бүсд хэрэгжүүлэх боломжтой.

Ангилал

Газар ашиглалтанд тулгарч буй асуудал:


Газар ашиглалт	Уур амьсгал	Доройтлын хэлбэр	Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл
			
Бэлчээр	Хуурай сэрүүн	Салхины элэгдэл	Ургамлын: Мод тарих
Техник үүрэг/үзүүлэх шууд нөлөө:		Техник үүрэг/үзүүлэх дам нөлөө:	
<ul style="list-style-type: none"> - салхины элэгдлээс хамгаална - салхины хүч буурна - биомасс нэмэгдэнэ 		<ul style="list-style-type: none"> - Суурин газрын ойролцоо байгаль, экологийн таатай нөхцөл бүрдэнэ - Модыг үржүүлэн худалдах 	

Байгаль орчин

Жилийн дундаж хур тунадас (мм)	Өндөршил (д.т.д м)	Гадаргын хэлбэр	Налуужилт (%)
			
Хөрсний гүн (см)	Ургамал ургах хугацаа: 160 өдөр (5-9 сар) Хөрсний үржил шим: Дунд Хөрсний бүтэц: Бүдүүн ширхэгтэй Гадаргын чулуурхаг байдал: Чулуу багатай Органик бодисын хэмжээ: Бага (0,6-1%) Ус нэвтрүүлэх чадвар: Муу Элэгдэл эвдрэлд өртөх байдал: Хүчтэй		Агаарын жилийн дундаж температур: 4 C° Хамгийн их/бага температур: +39/-36 Агаарын хамгийн их/бага даралт: 10 сард 873 /мб/, 3сард 827 /мб/ Агаарын жилийн дундаж даралт: 851.7 /мб/ Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа: Жилд 3120 цаг, 5-6 р сар буюу хамгийн ихдээ 315 цаг, 12-р сар буюу хамгийн багадаа 200 цаг байдаг байна.


Нийгэм-эдийн засаг

Нэг өрхөд ногдох ойтой талбай (га)



Газар ашиглалтын эрх: Нээлттэй
Газар эзэмшсэн эсэх: Нийтийн/Төрийн
Зах зээлийн төрөлжилт: Холимог (амь зуух, арилжаа наймаа)
Шаардагдах техник мэдлэгийн түвшин: Дунд: мэргэжилтэн/нэмэлт ажилчид
ХАА-аас гадна олох орлого, түүний ач холбогдол: 10-50%

Суурин/нүүдэлчин: Суурин
Ядуурлын түвшин: Дунд
Ажилгүйдлийн түвшин: Дунд
Нийгмийн зохион байгуулалт: Сайн



Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, үнэ өртөг

Үйл ажиллагааны дараалал	Байгуулахад гарах зардал /1 худаг гаргахад/, 1 \$-ыг 1000 төгрөгөөр бодов		
	Хөрөнгө оруулалт	өртөг (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1. Хамгаалалтын хашаа барих	Торон хашаа / 4800 м, 1 м-ийн үнэ 1500₮	7200	0%
2. Бордоо /бууц/ бэлдэх	Модон шон / 480 ш, нэг бүрийн үнэ 6000₮	2880	0%
3. Гүн өрмийн худаг гаргах	Төмөр шон / 480 ш, 1 бүрийн үнэ 10000₮		
4. Газраа хагалах	Хоолой /12000 м, 1 м-ийн үнэ 1400₮	4800	0%
5. Мод суулгах нүх ухах, арчлах	Крант / 126 ш, 1 бүрийн үнэ 7000₮	882	0%
6. Суулгацаа тарих	Насос / 2 ш, 1 бүрийн үнэ 450000₮	900	0%
7. Услах, арчлах	Гүний худаг / 3 ш, 1 бүрийн үнэ 13000000₮	39000	0%
	25 тоннын багтаамжтай ус нөөцлөх сав /2 ш, 1 бүрийн үнэ 1500000₮	3000	0%
	50 тоннын багтаамжтай ус нөөцлөх сав /2 ш, 1 бүрийн үнэ 3000000₮	6000	0%
	Нийт	81462	0%

Хүн хүчний өртөг	Бусад хөрөнгө оруулалт												
<table border="1"> <tr><td>■</td><td>Их</td></tr> <tr><td>□</td><td>Дунд</td></tr> <tr><td>□</td><td>Бага</td></tr> </table>	■	Их	□	Дунд	□	Бага	<table border="1"> <tr><td>■</td><td>Их</td></tr> <tr><td>□</td><td>Дунд</td></tr> <tr><td>□</td><td>Бага</td></tr> </table>	■	Их	□	Дунд	□	Бага
■	Их												
□	Дунд												
□	Бага												
■	Их												
□	Дунд												
□	Бага												

Тайлбар: Салхинаас хамгаалах ойн зурвасанд 3 ба түүнээс дээш настай, 1.5-2 м өндөртэй суулгацуудыг хэрэглэх бөгөөд зурвасны хэлбэрээс (нягт, сиймхий, сийрэг) хамааруулан мод хооронд 2-5 м, эгнээ хооронд 4-6 м зайтайгаар тооцоолж тарих ба тарилтын хугацааг 4 дүгээр сарын хоёрдугаар хагас 5 дугаар сарын эхний 10 хоногоос хэтрэлгүй тарих шаардлагатай.

Засаж сайжруулах үйл ажиллагаа	Урсгал зардал 1жилд /га-аар/		
	Гарах зардал	өртөг (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1. Нэмж худаг гаргах			
2. Тодорхой хугацааны давтамжтай хамгаалалтын хашааг янзалж засах			
3. Ойн зурвасанд тарьсан мод сөөгний төрөл зүйлийг нэмэгдүүлэх			
Тэмдэглэл: Ойн зурвасыг хамгаалах үүднээс манаач ажлуулж байгаа бөгөөд энэ нь тодорхой хэмжээний ажлын байрыг бий болгож өрхийн орлогыг нэмэгдүүлж байна. Цаашдаа ойн зурвасны талбайг нэмэгдүүлж, жимс ногоо тариалах болон мод сөөгний төрөл зүйлийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой. Мөн зурвас хооронд жимсний бут, сөөг, хүнсний ногоо тариалж агро-ойжуулалтын систем бүрдэх урьдчилсан нөхцөл хангагдсан байна.			
	Нэмж худаг гаргах	13000	0%
	Хашааг засварлах	200	0%
	Услалтын системийг шинэчлэх, засварлах	300	0%
	Нийт	13500	0%

Үнэлгээ

Үр ашиг /газар ашиглагчаас хамаарсан өртөг	Газар ашиглагчийн үзэж байгаагаар олсон ашиг	Богино хугацаанд	Урт хугацаанд
	Анх байгуулахад зарцуулагдсан зардалтай харьцуулахад олсон үр ашиг	Сөрөг	Эерэг
	Урсгал зардалтай харьцуулахад олсон үр ашиг	Эерэг	Сөрөг

Технологийн нөлөөлөл	Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн үр ашиг	Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн алдагдал
	+ + <input type="checkbox"/> Модны төрөл нэмэгдсэн	байхгүй
	+ + <input type="checkbox"/> Хамгаалал доройтлын талаарх мэдлэг нэмэгдсэн	байхгүй
	Экологийн үр ашиг	Экологийн алдагдал
	+ + + Хөрсний өнгөн давхарга сайжирсан	байхгүй
	+ + + Хөрсний чийг нэмэгдсэн	
	+ + + Биомасс нэмэгдсэн	
	+ + + Салхины хүрд	
	+ + + Хөрсний үржил шим сайжирсан	
	Дам үр ашиг	Дам сул тал
	байхгүй	байхгүй

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах	Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах
Ард иргэд өөрсдийн санаачлагаар байгуулсан → ард иргэдийг татан оролцуулж, дэмжих шаардлагатай	Гүний ус ашигладаг бөгөөд усны хүрэлцээ бага → усан байгуулах гэх мэт шинэ технологийг нэвтрүүлж, хуурай газарт дасан цохицох чадвартай мод, сөөгийг тарих
Биомасс нэмэгдэж, хөрсний чанар сайжирсан → иймэрхүү ажлыг дэмжиж, тэтгэлэг өгөх	Өндөр зардлаар байгуулагддаг → мод үржүүлэг болон модны нөмөрт хүнсний ногоо тариалж зардлаа нөхөх
Тухайн технологийг адил нөхцөлтэй бүс нутагуудад хэрэгжүүлэх бүрэн боломжтой → засгийн газраас санаачлагатай дэмжих	Хөрөнгө санхүүгийн бэрхшээл тулгардаг → төсөл боловсруулах замаар дэмжигч байгууллагуудтай хамтарч ажиллах

Холбоо барих байгууллага: ШУА-ийн Газарай - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар
Утас: 976-11-325487 **Факс:** 976-11-322187
Вебсайт: www.igg.ac.mn, www.geo-eco.mn